


ECONOMIC POLICY AND COMPETITIVENESS
RESEARCH CENTER

ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, ӨРСӨЛДӨХ
ЧАДВАРЫН СУДАЛГААНЫ ТӨВ



Банкуудын өрсөлдөөний тойм

2-р улирал,
2021



- ◇ Банкны салбарын мэдээ, мэдээлэл
- ◇ Үндсэн үзүүлэлтүүд
- ◇ Онцлох сэдэв: КОВИД-19 цар тахлын эсрэг Монголбанкаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ
- ◇ Арилжааны 11 банкны актив, зээл, хадгаламж, ашгийн хэмжээ

БАНКУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ТОЙМ

2021 он – II улирал

Банкны салбарын эргэн тойронд

04.01 Богд банк нь гадаад харилцаагаа өргөжүүлэх, худалдааны санхүүжилтийн бүтээгдэхүүн, үйлчилгээг идэвхжүүлэх шат дараалсан арга хэмжээг авч байгаа бөгөөд үүний хүрээнд Оросын Холбооны улсын томоохон банк болох РОСЭКСИМБАНК -тай корреспондент харилцаа тогтоож, худалдааны санхүүжилтийн эх үүсвэр авах шугам батлууллаа. Ингэснээр харилцагч болон хамтран ажиллагч байгууллагууд маань уг эх үүсвэрийн шугамыг ашиглан худалдааны санхүүжилт буюу баталгаа, аккредитивийн үйлчилгээг илүү таатай нөхцөлөөр авах, гадаад гүйвуулгыг илүү хурдан түргэн шуурхай гүйцэтгэх боломжтой болж байна. bogdbank.com

05.02 ХААН Банк “Ковид-19” цар тахалтай холбогдуулан төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй зээл (5%, 6% болон 8%) – ийн төлбөрийг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд хойшлуулах хүсэлтийг энэ 7-р сарыг дуустал онлайн аар хүлээн авч байна. Мөн өмнө нь буюу 2020 оны 10-р сарын 20-ны өдрөөс 2021 оны 1-р сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд ипотекийн зээлийн төлбөрөө хойшлуулж байсан харилцагчдын зээлийн гэрээнд автоматаар өөрчлөлт орж, төлбөр нь энэ оны 12-р сарын 31-ний өдрийг дуустал хойшлогдох тул дахин хүсэлт илгээх шаардлагагүй. khanbank.com

05.20 Дэлхийн банк санхүүгийн салбарын шилдгүүдийг тодорхойлдог “Global Finance” сэтгүүлээс зах зээлийн мэдлэг туршлага, дэвшилтэт технологи, програм хангамжийн шийдэл, олон улсын харилцагчдад үзүүлж буй үйлчилгээний чанар, мэргэжлийн байдал, харилцагчдын сэтгэл ханамж зэрэг үзүүлэлтүүдийг харгалзан ХААН Банкныг 2021 оны “Монгол Улсын шилдэг кастодиан банк”-аар 2 дахь жилдээ өргөмжиллөө. khanbank.com

05.25 “Ажлын байрыг дэмжих зээл”, Ипотекийн зээл болон Монголбанкны репо санхүүжилтийн зээлийг харилцагчдад хүртээмжтэй хүргэхэд Голомт банкны зүгээс дэмжин, хамтран ажиллаж байна. Тухайлбал, эдийн засгийн гол хөдөлгөгч хүч, ажлын байрыг бүрдүүлэгч жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын бизнесийн

үйл ажиллагааг сэргээх, ажлын байрыг хадгалах, дэмжих зорилготой 2 их наяд төгрөгийн санхүүжилт бүхий 3%-ийн хүүтэй “Ажлын байрыг дэмжих” зээлийн хүсэлтийг Голомт банк бүх салбар нэгжүүдээрээ дамжуулан хүлээн авч, шуурхай шийдвэрлэж байна. golomtbank.com




05.25 Монгол Улсын Засгийн газраас баталсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-нд тусгагдсан Ажлын байрыг дэмжих болон Хөдөө аж ахуйн 3 хувийн хүүтэй зээлийг олгоход ХААН Банк дэмжин хамтран ажиллаж байна. Энэхүү төлөвлөгөөний хүрээнд Ажлын байрыг дэмжих гурван хувийн хүүтэй зээлийн хүсэлтийг өнгөрсөн 2-р сараас хойш орон даяар байрлах бүх салбар нэгжээрээ дамжуулан хүлээн авч, шийдвэрлэж байгаа бөгөөд 2021 оны 5-р сарын 26-ны өдрийн байдлаар 5965 харилцагчид 491.3 тэрбум төгрөгийн зээл олгосон бол 1201 харилцагчийн 80.9 тэрбум төгрөгийн зээлийг дахин санхүүжүүлээд байна. Ингэснээр нийт 17,906 ажлын байрыг хадгалж үлдээд байна. Харин хөдөө аж ахуйн зээлийн хувьд нийт 3,363 харилцагчид 228 тэрбум төгрөгийн зээл олгожээ. khanbank.com

06.03 Худалдаа, хөгжлийн банк (ХХБ)-ны “Climate 30+ Тогтвортой санхүүжилтийн санаачилга” дор боловсруулсан Ногоон зээлийн хөтөлбөр (2021-2026) -ийн хэрэгжилтэд 10 сая ам. долларын ногоон санхүүжилтийг Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны банк (ОУЭЗХАБ)-наас амжилттай татаж, ногоон бизнесийн загварыг Монгол Улсад нэвтрүүлэн хөгжүүлэхэд хамтран ажиллахаар боллоо. tdbm.mn

БАНКУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ТОЙМ

2021 он – II улирал

Банкны салбарын гол үзүүлэлтүүд¹



Нийт актив = 39.9 их наяд төгрөг

Банкны салбарын нийт актив 2021 оны 2-р улиралд 39.9 их наяд төгрөг болж өмнөх улирлаас 2.7 их наяд (7.3%) төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 5.6 их наяд (16%) төгрөгөөр тус тус өссөн байна.

Алдагдал = 322.8 тэрбум төгрөг

Банкуудын өөрийн хөрөнгө 2021 оны 2-р улирлын байдлаар 3.82 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үеэс 0.02 их наяд төгрөгөөр буурчээ. Харин банкны салбарын ашиг 2-р улирлын байдлаар 322.8 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.

Банкны нөөц = 3.6 их наяд төгрөг

Банкны нөөц 2021 оны 2-р улирлын байдлаар 3.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1 их наяд төгрөгөөр буурчээ. Харин өмнөх улиралтай харьцуулахад 373 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Чанаргүй зээл 9%

Нийт дотоодын зээл (цэвэр) 2021 оны 2-р улирлын байдлаар 17.67 их наяд төгрөг болж өсөв. Чанаргүй зээлийн хэмжээ мөн өсөж 2-р улирлын байдлаар нийт чанаргүй зээл 1.5 их наяд төгрөг буюу нийт зээлийн (цэвэр) 9%-ийг эзэлж байна.

¹ Эх сурвалж: Банкуудын нэгдсэн балансын гол үзүүлэлтүүд, Монголбанк

БАНКУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ТОЙМ

2021 он – II улирал


Ипотек = 5.18 их наяд төгрөг

Ипотекийн зээлийн үлдэгдэл 2021 оны 2-р улирлын байдлаар 5.18 их наяд төгрөг буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.7%-иар өссөн байна.




1 USD = 2849.1 MNT 1 CNY = 443.2

Монголбанкнаас зарласан ханшийн сарын дундаж хөдөлгөөнөөр 2021 оны 6-р сарын дундаж Ам.доллар-ын ханш 2849.1₮, Юань-ийн ханш 443.2₮ байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Ам.долларын ханш 3.9₮-р (-0.1%) буурсан бол, Юанийн ханш 19.2₮-р (+0.4%) өссөн байна.



Харилцах+Хадгаламж=25.9 их наяд ₮

2021 оны 2-р улирлын байдлаар банкны салбарын нийт хадгаламжийн хэмжээ 18.57 их наяд төгрөг, харилцах 7.3 их наяд төгрөг байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хадгаламж 28%-иар өсөж, харилцах 44%-иар өссөн байна.



Пассив = 36.9 их наяд төгрөг

2021 оны 2-р улирлын байдлаар банкны салбарын нийт пассив (өр төлбөр) 36.9 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 5.7 их наяд (18.3%) төгрөгөөр нэмэгджээ.



Онцлох: КОВИД-19 цар тахлын эсрэг Монголбанкнаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

Олон улсын валютын сангийн хөтөлбөрийн хүрээнд, бусад төв банкуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг судалж, өөрийн орны онцлогт тохирсон бодлогын цогц арга хэмжээг Монголбанкнаас авч хэрэгжүүлж байна.

1. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих, ханшийн эрсдэлийг бууруулах зорилгоор гадаад валютын своп хэлцлийг тогтмол хийж байна

Банкуудын богино хугацааны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангахад дэмжлэг үзүүлэх, валютын ханшийн эрсдэлээс хамгаалах, төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг зорилгоор Монголбанк төгрөг-ам.долларын своп хэлцлийг банкуудтай тогтмол хийж байна. Монголбанк оны эхнээс богино хугацаат репо санхүүжилтээр оны эхний 9 сарын байдлаар 2.4 их наяд төгрөг, гадаад валютын своп хэлцлээр 1.7 их наяд төгрөгийн нөөцийг банк хоорондын захад нийлүүлээд байна.

2. Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журамд түр хугацааны өөрчлөлт оруулав

КОВИД-19 вирусн тархалттай холбоотойгоор Монгол Улсын эдийн засагт хүндрэл учирч, банкны салбарын зээлийн эргэн төлөлтөд доголдол үүсч байгаатай холбогдуулан Монголбанкнаас дараах журмуудын тодорхой зохицуулалтыг доорх нөхцөлтэйгөөр **түр хугацаагаар буюу** 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэл мөрдүүлэхээр шийдвэрлэв. Энэхүү зохицуулалтын хүрээнд 10-р сарын 1-ний байдлаар 3.7 их наяд төгрөгийн зээлд бүтцийн өөрчлөлт хийгдсэний 2.2 их наяд төгрөг нь бизнесийн зээл байна.

3. Эргэн төлөлт нь хүндрэлд орсон зээлдэгчийн хэрэглээний зээлийн хугацааг сунгах шийдвэр гаргалаа

Мөнгөний бодлогын хорооны ээлжит болон ээлжит бус хурлуудын шийдвэрээр эргэн төлөлт нь хүндрэлд орсон зээлдэгчийн хэрэглээний зээлийн хугацааг 12 хүртэлх сараар сунгах шийдвэр гаргалаа. Энэхүү арга хэмжээ нь 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл зээлдэгчдийн зээлийн сарын төлбөрийн дарамт буурч гар дээр үлдэх орлого нэмэгдсэнээр хувийн хэрэглээг урамшуулах, улмаар үүсээд буй өнөөгийн хүндрэлийг зөөлрүүлэх, эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх нөлөөтэй юм. Энэ хүрээнд 10-р сарын 1-ний өдрийн байдлаар 1.5 их наяд төгрөгийн хэрэглээний зээлийн нөхцөлд өөрчлөлт орсон байна.

4. Төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй хүүтэй зээлийн эргэн төлөлтийг түр хугацаагаар хойшлууллаа

Зээлдэгчийн зээлийн эргэн төлөх нөхцөлийг дахин өөрчлөх, эргэн төлөлтийн доголдолтой зээлийн ангилал, зээлийн түүхийг түр хугацаанд бууруулахгүй байх асуудлыг бие даан шийдвэрлэх боломжийг банкуудад олгоод байгаа билээ. 10-р сарын 1-ний өдрийн байдлаар нийт 38,152 зээлдэгчийн 2.0 их наяд төгрөгийн зээлийн төлбөрийг 6 сарын хугацаатайгаар хойшлуулсан.

5. Төв банкны хүүний коридорын өргөнийг нарийсгаж, бодлогын хүүгээс +/- 1 нэгж хувиар тогтоов

Мөнгөний бодлогын хорооноос 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдөр хүүний коридорыг +/- 1 өргөнтэй болгож нарийсгах шийдвэр гаргасан нь банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих, илүү бага хүүгээр Төв банкнаас репо санхүүжилт авах бололцоог бий болгох зорилготой юм.

БАНКУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ТОЙМ

2021 он – II улирал

Банкуудын өрсөлдөөн

Арилжааны банкны үндсэн үүрэг нь мөнгөн хөрөнгийн илүүдэлтэй байгаа хэсгээс хөрөнгийг татаж, дутагдалтай байгаа хэсэгт шилжүүлэн, харилцагчдын итгэл дээр суурилсан санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа үзүүлэх, харилцагчдын хоорондын төлбөр тооцоог хийж гүйцэтгэх бөгөөд эцсийн зорилго нь санхүүгийн үйлчилгээгээр дамжуулан ашиг олох явдал билээ.

2021 оны 1-р улирлын байдлаар банкны салбарт нийт 11 арилжааны банк үйл ажиллагаа явуулж байна. Монголбанкны тодорхойлсноор банкны системд нөлөө бүхий банкуудад Хаан банк, ХХБ, Голомт банк, Хасбанк, Төрийн банк гэсэн 5 банк багтаж байна. Эдгээр банкууд нь системийн 90-ээс дээш хувийг бүрдүүлж буй юм.

Арилжааны банкуудын санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, өөрчлөлт хөдөлгөөнийг харуулдаг мэдээллийн гол эх сурвалж бол банкуудын санхүүгийн тайлан юм. Банкуудын өрсөлдөөний тоймыг гаргахдаа санхүүгийн хураангуй тайланг ашиглан дараах үзүүлэлтүүдийг харьцуулсан болно. Үүнд:

- Актив
- Зээл
- Харилцах, хадгаламж
- Ашиг

Эдгээр үзүүлэлтээр арилжааны банкуудыг харьцуулахдаа активын хэмжээгээр нь Том-3 банк, Дунд-2 банк, бусад банкууд гэж ангилсан.



АКТИВ

БАНКУУД

ТОМ-3 БАНК

>5 их наяд төгрөг

Худалдаа хөгжлийн банк
Хаан банк
Голомт банк

ДУНД-2 БАНК

1-5 их наяд төгрөг

Хасбанк
Төрийн банк

ЖИЖИГ БАНКУУД

<1 их наяд төгрөг

Чингис хаан банк
Капитрон банк
Үндэсний хөрөнгө оруулалтын банк
Ариг банк
Богд банк
Тээвэр хөгжлийн банк


БАНКУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ТОЙМ

2021 он – II улирал




Тайлант хугацаанд тайланд орсон 11 банкны нийт актив 34 их наяд төгрөг байна. Том-3 банк нийт активын 75.8%, Дунд-2 банк 18.4%, жижиг банкууд 5.8%-ийг эзэлж байна.

1 жилийн өмнөх мөн үетэй харьцуулахад том-3 банкны актив 20%, дунд-2 банкны актив 10%, жижиг банкуудын актив 0.6%-иар өсчээ.

АКТИВ



Банкуудын активын хэмжээ, тэрбум төгрөгөөр болон өсөлтийн хувь



БАНКУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ТОЙМ


2021 он – II улирал

ЗЭЭЛ




Тайлант хугацаанд тайланд орсон 11 банкны нийт зээлийн үлдэгдэл 16.5 их наяд төгрөг байна. Үүнээс 73.7%-г Том-3 банк, 19.7%-г Дунд-2 банк, 6.5%-г жижиг банкууд бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад зээлийн хэмжээ Том-3 банк 12%-иар, Дунд-2 банк 10%-иар өссөн бол жижиг банкууд 11%-иар буурсан байна. Харин нийт дүнгээр авч үзвэл банкуудын зээлийн хэмжээ сүүлийн нэг жилд 9.6%-иар буурчээ.

Зах зээлд эзлэх хувь, 2У'21



Зээлийн хэмжээ, тэрбум төгрөг болон өсөлтийн хувиар




БАНКУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ТОЙМ

2021 он – II улирал




ХАДГАЛАМЖ БА ХАРИЛЦАХ

Тайлант хугацаанд тайланд орсон нийт 11 банкны харилцах ба хадгаламжийн хэмжээ 28 их наяд төгрөг байна. Үүнээс 76.4%-г Том-3 банк, 18.6%-г Дунд-2 банк, 4.9%-г жижиг банкууд эзэлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Том-3 банк 27%-иар, Дунд-2 банк 19%-иар, жижиг банкууд 5%-иар харилцах хадгаламжийн хэмжээгээ нэмэгдүүлсэн байна. Нийт дүнгээр нь авч үзвэл харилцах болон хадгаламжийн хэмжээ 1.2%-иар өсчээ.



Хадгаламж ба харилцахын хэмжээ, тэрбум төгрөгөөр болон өсөлт






БАНКУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ТОЙМ

2021 он – II улирал

АШИГ

2021 оны 2-р улирлын байдлаар тайланд орсон 11 арилжааны банкуудын санхүүгийн тайлангийн нийлбэр дүнгээр банкууд нийт 379 тэрбум төгрөгийн ашигтай (татварын өмнөх дүн) ажиллажээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Том-3 банкны ашиг 73%-иар буюу 106 тэрбум төгрөгөөр буурсан бол Дунд-2 банкны ашиг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 108%-иар өсөж 35 тэрбум төгрөгийн ашигтай ажиллажээ. Харин жижиг банкуудын хувьд 76.53 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллажээ.

Банкуудын ашиг, алдагдал (тэрбум төгрөгөөр):



Эх сурвалж:

1. Статистикийн бюллетень 2У'21, Монголбанк
2. Банкуудын нэгдсэн балансын гол үзүүлэлтүүд 2У'21, Монголбанк
3. Монголбанкны ханшийн сарын дундаж хөдөлгөөн, Монголбанк
4. Арилжааны банкуудын улирлын санхүүгийн тайлан 2У'21
5. Арилжааны банкуудын зээлийн тайлан, 2021 оны 6-р сар